



**ЭМЭЭЛТИЙН ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН  
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ**

2015 оны 12 сарын 31 өдөр

Дугаар A/49

Улаанбаатар хот

Г Сонгон шалгаруулах байнгын Г  
комисс байгуулах тухай

“Эмээлтийн Хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.8 дах хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Эмээлтийн Хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын сул орон тоог нөхөх албан тушаалын сонгон шалгаруулалтын зар, тухайн албан тушаалд **тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадвар** болон тусгай шаардлагыг хангаж, ажиллахыг хүссэн иргэнийг бүртгэх, сонгон шалгаруулах үүрэг бүхий Сонгон шалгаруулах байнгын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

- Хөрөнгө оруулалтын мэргэжилтэн Б.Алтан-Очир

Гишүүд:

- Төслийн багийн ахлагч,  
барилга байгууламжийн инженер Г.Пүрэвдорж
- Санхүү, аж ахуйн багийн ахлагч, нягтлан бодогч Г.Батням

Нарийн бичгийн дарга:

- Хүний нөөцийн мэргэжилтэн Т.Түвшинзаяа

2. Сул орон тоог нөхөх албан тушаалын жагсаалт, холбогдох зардлыг батлуулж, сонгон шалгаруулалтын зар, тухайн албан тушаалд **тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадвар** болон тусгай шаардлага, ажиллахыг хүссэн иргэнийг бүртгэж, сонгон шалгаруулалтын дүнг 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр Даргын зөвлөлд танилцуулахыг Сонгон шалгаруулах байнгын комисст үүрэг болгосугай.


3. “Эмээлтийн Хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын албан хаагчийг сонгон шалгаруулах журмыг 2016 оны 01 дүгээр сарын 19-ны дотор боловсруулж, батлуулахыг Сонгон



шалгаруулах байнгын комиссын дарга /Хөрөнгө оруулалтын мэргэжилтэн Б.Алтан-Очир/-д даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрх зүйч, зөвшөөрлийн мэргэжилтэнд даалгасугай.

ДАРГА



М.ГОНЧИГЖАВ